

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө болон албаны даргын 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр баталсан 29/01 тоот удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

1.Аудитын зорилго:

Сумдын ЗДТГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар хөтлөгдсөн эсэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудалд зөвлөгөө өгөх.

2.Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитаас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт өгөгдсөн тул санхүүгийн тайлагналын хэсгийг хамруулахгүй.

Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмжүүд
1.Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө хийхдээ төсөв санхүүтэйгээ уялдуулан хийдэггүй.	1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийж батлуулахдаа батлагдсан төсөвтэйгөө уялдуулан арга хэмжээ бүрд шаардагдах хөрөнгийн хэмжээг тусган сумын Засаг даргаар батлуулж хэвших 2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд арга хэмжээ бүрд зарцуулсан хөрөнгийг тусгаж байх 3.Төсөв хөрөнгө хүрэлцэхгүй байгаа болон хэрэгжүүлэхэд хөрөнгө байхгүй арга хэмжээг дараа онд хэрэгжүүлэхээр хойшлуулах зэргээр зохицуулалтыг хийж, тайландаа тусган ажиллах
2.Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.	1.Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох 2.Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх 3.Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах

	<p>эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах</p> <p>4.Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх</p> <p>5.Тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах</p> <p>6.Эрсдэлийн удирдлагыг гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгэн хэсэг болгон тайлагнах</p> <p>7.Удирдлагыг эрсдэлийн удирдлагын мэдээллээр хангах</p> <p>8.Нэг албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхижуулах</p> <p>9.Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтанг сонгон шалгаруулж авах</p> <p>10.Байгууллагын эрсдлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>
<p>3.Дотоод хяналтын нэгж эрсдэлд чиглэсэн хяналтыг хийдэггүй, жил бүр нэг хэв маягаар ор нэр төдий хяналтыг хийдэг.</p>	<p>1.ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт хийх дотоод хяналтын нэгжийг байгуулах</p> <p>2.Дотоод хяналтын нэгжийн журмаа өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинэчлэх</p> <p>3.Журмандаа дотоод хяналтын нэгжид ажлыг сайжруулах талаар тусгаж, ажлыг үнэлэн, биелэлтийг тооцон хууль тогтоомжид нийцсэн урамшууллын хөшүүргийг тусгаж өгөх</p> <p>4.Дотоод хяналтын нэгжийн албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх байгууллагын сургалтад хамруулж мэргэшүүлэх</p> <p>5.Дотоод хяналтын нэгжийн жилийн төлөвлөгөөг эрсдэлд суурилан төлөвлөх</p>

	6.Дотоод хяналтын зураглалтай болох, түүнийг хамт олноороо мөрддөг байх
4.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй	1.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулахын тулд мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөө, сургалт авах 2.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулан баталж, мөрдөж ажиллах
5.Төрийн албан хаагчид хууль тогтоомжид нийцээгүй нэмэгдлүүд, Засаг даргад буруу шийдвэр гаргаж үр дүнгийн урамшуулал олгосон	1.Захирамж, тушаал шийдвэрийг төлөвлөн гаргахдаа хууль эрх зүйн мэргэжилтнээр тогтмол хянуулж байх 2.Санхүүгийн ажилтан сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нартаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах 3.Цалин хөлс, төсөв хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг гаргахдаа хууль тогтоомжийг үндэслэхэд эргэлзээтэй асуудал гарахад мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөө авч ажиллах 4.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үүргээ гүйцэтгэж байхад нэмэгдэл олгохоор шийдвэр гаргадаг үйл ажиллагааг таслан зогсоох, дахин ийм буруу шийдвэр гаргахгүй байх 5.Бүтэц орон тоонд батлагдсан эзгүй байгаа албан хаагчийн ажил үүргийг орлон гүйцэтгэж байгаа үед нэмэгдэл олгохоос бус орон тоонд батлагдаагүй ажил үүргийг гүйцэтгэхэд хавсарсны болон бусад нэмэгдлүүдийг сар бүр тогтмол олгохоор хууль бус шийдвэрийг дахин гаргахгүй байх
6.Зарим саруудын цагийн баланс зөрүүтэй, Засаг даргын үр дүнгийн урамшуулал, цалингийн нэмэгдлийг илүү олгосон	1.Цагийн балансыг үнэн зөв гаргаж, сайтар шалгаж баталгаажуулдаг байх. 2.Дотоод хяналтын баг цагийн баланс гаргалт, цалин бодолтод хяналтыг хэрэгжүүлж ажиллах 3.Санхүүгийн албаны даргад орон нутгийн хөгжлийн сан, худалдан авах

	<p>ажиллагааны сан хариуцсаны нэмэгдэл, бусад албан хаагчид хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг төрийн жинхэнэ албан хаагчийн цалин хөлсөнд тусгагдаагүй нэмэгдлийг сар бүр тогтмол олгохгүй байх</p> <p>4.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй ажил үүргийг чанартай сайн гүйцэтгэсэн тохиолдолд ажлын үр дүнтэй уялдуулан урамшуулал хэлбэрээр олгохоор зохицуулж ажиллах</p> <p>5.Ажлын байрны болон чиг үүргийн шинжилгээ хийж гарсан үр дүнд үндэслэн хийдэлтэй байгаа чиг үүргүүдийг эзэнжүүлж албан тушаалын тодорхойлолтод тусгаж ажиллах.</p>
<p>7.Бичиг хэрэг, шатахууны тайланд орлого дутуу авдаг, шаардах хуудсаар зарцуулалт дутуу, бараа материалын тайланг зөрүүлж, алдаатай тайлан гаргадаг, нягтлан бодогчийн хяналт муу.</p>	<p>1.Няравын програмд мэдээллүүдийг үнэн зөв оруулж, програм ашиглаж тайлан гаргах</p> <p>2.Бараа материалыг орлогод бүрэн авч анхан шатны баримтыг үндэслэн зарцуулалтыг гаргадаг байх</p> <p>3.Аж ахуйн материалын тайланг анхан шатны баримттай нь тулган шалгаж хүлээж авдаг байх</p> <p>4.Няравыг мэргэжил арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд нь өдөр тутам хяналтыг хэрэгжүүлж ажиллах</p> <p>5.Санхүүгийн ажилтнууд солигдсон, шинэчлэгдсэн, түр эзгүй байх хугацаанд түр орлон ажиллаж байгаа албан хаагч нарын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, дотоод хяналтын нэгж үүнд хяналт тавьж ажиллах. Ажил хүлээлцэхдээ холбогдох баримт бичиг, тайланг бүрэн хүлээлцэж хэвших.</p>
<p>8.Харилцагч аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй тооцоо нийлсэн актыг үйлдээгүй.</p>	<p>1.Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн холбогдолтой хууль, журам, заавартай сайтар танилцаж судлах</p> <p>2.Харилцагч иргэн, аж ахуй нэгжтэй тооцоо нийлсэн актыг бүрэн үйлдэж байх</p> <p>3.Өр авлагаа баталгаажуулж ажиллах</p>

	Мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөөг тогтмол авч ажиллах
--	---